



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 11

Арвайхээр

Дэд хөтөлбөр батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33.1 дэх заалт, Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03/03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Багшийн хөгжил" аймгийн хөтөлбөр(2025-2028 он), Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн Удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Сургуулийн дүрэм"-ийн 3.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн 2025-2028 онд хэрэгжүүлэх "Багшийн хөгжил" дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, чанар, үр дүнтэй хэрэгжүүлэн, үр дүнг Удирдах зөвлөлийн хуралд тайлагнахыг сургуулийн Захирал (С.Санчир)-д үүрэг болгосугай.
3. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсвийн зохих зүйл ангиас зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч (С.Хандсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



О.ГАНСҮХ

Удирдах зөвлөлийн 2025 оны  
02 сарын 06-ны өдрийн 19 дугаар  
тогтоолын 01 хавсралт



**БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА ӨВӨРХАНГАЙ  
АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН БАГШИЙН  
ХӨГЖЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨР (2025-2028 он)**

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Аливаа сургалтын байгууллагын тогтвортой үйл ажиллагааны гол үндэс нь багшийн хөгжил юм. Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байна. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Өвөрхангай аймгийн Иргэдийн хурлын 2025 оны 02-р сарын 17-ны өдрийн 03/03 тогтоолоор батлагдсан “Багшийн хөгжлийн хөтөлбөр”, Политехник коллежийн “Стратеги төлөвлөгөө” (2025-2028) зэрэгтэй уялдуулан сургуулийн багшийн хөгжлийн дэд хөтөлбөр боловсруулах үндэслэл урган гарч байна.

2025 оны байдлаар тус сургуульд 68 багш ажиллаж байгаа бөгөөд нийт багшид магистрын зэрэгтэй багшийн эзлэх хувь 31%, бакалаврын зэрэгтэй 65%, дипломын боловсролтой багшийн эзлэх хувь 4% байна. Мэргэжлийн зэргээр авч үзвэл зөвлөх багш 4,4%, тэргүүлэх багш 6,8%, заах аргач багш 41,1% тус тус эзлэж байгаа нь дипломын боловсрол олгох сургалттай боловсролын байгууллагын хувьд багшийн боловсролын зэрэг, албан тушаалын ангилалын шатлалыг ахиулах, түүгээр дамжуулан багш хөгжих зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. Зарим мэргэжлийн болоод ерөнхий эрдмийн багшийн хомсдол бий болоод байгаа бөгөөд багш нарыг хөрвөн суралцахад онцгой анхаарах асуудал тулгарч байна.

21-р зууны суралцагчийг 20-р зууны сургалтын аргаар сургах боломжгүй юм. Багшийн арга зүйг сайжруулах нь тэдэнд зориулсан сургалтаар бүрэн шийдэгдэхгүй, багшлахуйн мэдлэгээс гадна арга зүй, технологийн мэдлэгийн хослолд суурилан, багш өөрөө сургалтын үйл ажиллагааг бүтээлчээр удирдан, сургах-сурах зүйн оновчтой шийдлийн төлөө шинэ санаа, бүтээлч арга зүйг судлан хэрэгжүүлэх, бүтээн туршиж, сайжруулахын төлөө ажиллах зайлшгүй шаардлага бий болоод байна. Багшийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг, багшийн бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн байгууллагын соёл зайлшгүй шаардлагатай байна. Эдгээр хэрэгцээ, шаардлагын улмаас, дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд үндэслэн, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаалын тодорхойлолт, үүрэг хариуцлага, ур чадвар болон чадамж, багшид тавигдах нийтлэг шаардлага, багшийн имидж, багшийн үнэлгээ урамшууллын механизм, багшийг хөгжүүлэх сургалтын систем, карьер хөгжил зэрэгт тулгуурлаж багшийн хөгжлийн дэд хөтөлбөр боловсруулагдаж байна.

Багшийн хөгжил, тэдний нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн боловсролын чанарыг сайжруулан, багшийн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэхэд уг хөтөлбөрийн ач холбогдол оршино.

### **Хоёр. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО**

Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн багшийн арга зүй, багш боловсролын мэргэжлийн дизайнер байх ур чадварыг нэмэгдүүлж, байгууллагын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэх замаар тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжихэд оршино.

### **Гурав. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ**

3.1 Багш, ажилтны хөгжил, нэр хүнд, имиджийг өсгөх, хөрвөх, бүтээлч үйл ажиллагааг дэмжинэ.

3.2 Багшийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын арга зүйг дээшлүүлэх, ном товхимол хэвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжинэ.

3.3 Багш, ажилтныг ажлын байран дээр сургах, хөгжүүлэх, үнэлэх, дэмжихэд зарцуулагдах эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

### **Дөрөв.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ**

4.1 Хөтөлбөрийг 2025-2028 он дуустал 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

4.2 Энэхүү хөтөлбөр нь багш, удирдах ажилтан, арга зүйч нар, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш нарын хүрээнд үйлчилнэ.

### **Тав.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Зорилт 1. Багш, ажилтны хөгжил, нэр хүнд, имиджийг өсгөх, хөрвөх, бүтээлч үйл ажиллагааг дэмжих хүрээнд:**

5.1.1 “Багшийн хөгжлийн төв”-ийг засварлан, багшид тав тухтай, хөгжих ээлтэй орчин, нөхцөл бүрдүүлэх;

5.1.2 Мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулах, сургагч болон чиглүүлэгч (ментор) багшийг бэлтгэн, сайн туршлага, арга зүйг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, соёлын мэдрэмжтэй сургах зүйд багшийг сургах;

5.1.3 Дундын мэдээллийн сантай байх;

5.1.4 Багш, ажилтны манлайллыг сайжруулах, нэр хүнд үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой үйл ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.1.5 Бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар, хөрвөх чадвартай багшийн хөгжлийг өсгөх;

5.1.6 Мэргэжлийн сургуулийн үнэ цэн, үйл ажиллагаа, ур чадвар, ололт амжилтыг сурталчлах, цахим контент бэлтгэн түгээн дэлгэрүүлэх;

**Зорилт 2. Багшийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын арга зүйг дээшлүүлэх, ном товхимол хэвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх хүрээнд:**

5.2.1 Судалгааны болон сургалтын арга зүйн мэдлэг, ур чадварыг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн танхим, онлайн хосолсон хайбрид сургалтыг зохион байгуулах;

5.2.2 Бүс, улсын хэмжээнд “Багш-багш, багш-инженер айлчлал” арга хэмжээг хэрэгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар тэргүүлэгч шилдэг менежменттэй сургуулиудаас туршлага судлах, сайн туршлага, арга зүйг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

5.2.3 Багш, ажилтны гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэх, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх;

5.2.4 Боловсролын болон мэргэжлийн тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй багш, удирдах ажилтан, судлаач багшийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

5.2.5 Гарын авлага, ном, товхимол бэлтгэн гаргаж байгаа багш нарт арга зүйн зөвлөгөө өгч, хэвлэлтэд дэмжлэг үзүүлэх;

**Зорилт 3. Багш, ажилтныг ажлын байран дээр сургах, хөгжүүлэх, үнэлэх, дэмжихэд зарцуулагдах эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд:**

5.3.1 Багш, ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоог үр дүнтэй зохион байгуулах, эмчлүүлэхэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх;

5.3.2 Багш, ажилтны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээнд хамруулах боломжийг судлан хэрэгжүүлэх;

5.3.3 Нэн шаардлагатай мэргэжлээр багш бэлтгэх, багшийн нөөц бүрдүүлэх чиглэлээр инженер бэлтгэдэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллах;

5.3.4 Чадварлаг багш, ажилтны болон мэргэжлийн хөгжлийн бүлгийн ур чадвар, манлайллыг хөхүүлэн дэмжих, урамшуулах;

5.3.5 Багш, ажилтныг компьютер, шаардлагатай техник хэрэгслээр үе шаттай хангах;

5.3.6 Багш, ажилтныг ажлын байран дээр хөгжүүлэхэд төсөл, хөтөлбөр болон хамтран ажилладаг аж ахуйн нэгж байгууллагаас дэмжлэг авах;

**Зургаа.ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин			
			2025	2026	2027	2028
1.Багш, ажилтны хөгжил, нэр хүнд, имиджийг өсгөх, хөрвөх, бүтээлч үйл ажиллагааг дэмжинэ.	1. “Багш хөгжлийн төв”-ийн засвар үйлчилгээ, тохижилт	20%	60%	100%	-	-
	2.Судлагдхуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгийн тоо	0	6	-	-	-
	3.Суралцахууд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгийн тоо	0	4	2	1:	-
	4.Дундын мэдээллийн сангийн тоо	0	1	2	3	-
	5 Багшийн амжилтыг					

	сурталчлах нэвтрүүлэг, цахим контент бэлтгэн, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэлт хийсэн тоо	35	45	45	50	50
2.Багшийн сургалт, инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг дээшлүүлнэ.	1.Сургалтын заах арга зүйн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалтын тоо	0	1	2	2	2
	2.Судалгааны ажлын шинэ арга зүйд суралцах сургалтын тоо	0	1	2	2	2
	3.Менти багш нарыг дагалдуулан сургах ментор багш нарын тоо	7	15	20	25	30
	4. Багш, ажилтны эрдэм шинжилгээ, онол практикийн хурлын тоо	1	2	2	2	2
	5."Багш-багш, багш-инженер айлчлал" арга хэмжээнд хамрагдсан багш, албан хаагчийн тоо	1	4	6	8	10
	6.Гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан багш, ажилтны тоо	2	16	16	20	25
	7. Мэргэшлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь	52.3%	55%	60%	65%	70%
	8.Магистрын зэрэг хамгаалсан багшийн тоо	1	2	2	3	5
3.Багш, ажилтныг ажлын байран дээр дээр сургах, хөгжүүлэх, үнэлэх, дэмжихэд зарцуулагдах эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	1.Багш, ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамрагдсан тоо	82	88	90	96	100
	2.Магистр, докторын сургалтанд хамрагдаж, санхүүгийн дэмжлэг авч буй багшийн тоо	1	2	2	3	5
	3.Мэргэжлийн багшийн нөөц бүрдүүлэх чиглэлээр хамтран ажилладаг их дээд сургуулийн тоо	0	1	2	-	-

	4.Багш, ажилтанд шинээр олгосон компьютер, принтерээр хангасан тоо	15	15	15	18	20
	5.Төсөл хөтөлбөр, хамтран ажилладаг аж ахуйн нэгж байгууллагаас дэмжлэг авсан багшийн тоо	0	2	2	2	2

### **Долоо.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН**

- 7.1 Багшийн хөгжлийн төвийг шинэчлэн багшийн хөгжилд ээлтэй орчин нөхцөл бий болсон байна.
- 7.2 Сургуулийн хэмжээнд багшийн хөгжлийг дэмжих бодлого тодорхой болж, хөгжүүлэх асуудал нь тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломж бүрдэнэ.
- 7.3 Багш, ажилтнуудын багаар ажиллах арга барилд ахиц гарч, харилцан суралцах боломжийг бүрдүүлсэн мэргэжлийн хөгжлийн бүлгүүд шинээр бий болж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.
- 7.4 Дотоод, гадаадын сургалтын тоо, төрөл, сургалтад хамрагдсан багшийн тоо нэмэгдэнэ.
- 7.5 Мэргэжлийн багш, хүний нөөцийг бүрдүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, багшийн хангалтыг сайжруулсан байна.
- 7.6 Багш, ажилтныг ажлын байран дээр хөгжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна.

### **Найм. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ, САНХҮҮЖИЛТ**

#### **8.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

8.1.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг Сургалтын алба хариуцна.

8.1.2 Сургалтын албанаас гаргасан төлөвлөгөөний дагуу багш, удирдах ажилтан, арга зүйч нар, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрын багш нар хэрэгжүүлж ажиллана.

#### **8.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээ**

8.2.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг чанарын баталгаажилт, дотоод хяналтын алба гүйцэтгэж үр дүнг Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

8.2.2 Хөтөлбөрийн явцын хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

#### **8.3 Хөтөлбөрийн санхүүжилт**

8.3.1 Улсын болон орон нутгийн төсөв

8.3.2 Бусад эх үүсвэрийн санхүүжилт